

Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2023 оны дотоод аудитын төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан 29/01 тоот удирдамжийн дагуу Гэр бүл хүний хөгжлийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

1.Аудитын зорилго:

Гэр бүл хүний хөгжлийн төвийн төсөв санхүүгийн үйл ажиллагаа үр ашигтай төлөвлөгдөж, зарцуулагдаж байгаа эсэх, ашигт ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдсэн ажлын үр дүн, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй дотоод хяналтууд хэрэгждэг эсэх, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, шилэн данс хөтлөлт чанартай хийгдэж байгаа эсэх зэрэгт үнэлэлт дүгнэлт хийх, илэрсэн асуудал болон ашигт ажиллагааг сайжруулах чиглэлээр зөвлөгөө өгөх.

2.Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

Энэ удаагийн дотоод аудитыг зөвхөн санхүүгийн үйл ажиллагаанд чиглүүлэхийг зорьсон, мөн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цаг хугацаанд аудитыг багтааж, үр дүнг тайлагнах шаардлагатай тул байгууллагын засаглалын бүтэц, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг бүхэлд нь авч үзэхгүй зөвхөн санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох хэсгийг хамруулна. Мөн Төрийн аудитаас санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж дүгнэлт өгөгдөх тул санхүүгийн тайлагналын хэсгийг хамруулахгүй.

№	Илэрсэн асуудлууд	Өгсөн зөвлөмж
1	Гэр бүл хүний хөгжлийн төвийн гүйцэтгэх захирал нь аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулаагүй, аймгийн ИТХурлаас ажлыг нь үнэлж дүгнэдэггүй, үйл ажиллагаа нь урсгалаараа явагддаг.	1. Байгууллагын дүрмэнд өөрчлөлт оруулж, орон нутгийн өмчийн оролцоот аж ахуйн нэгжид шилжүүлэх ажлыг зохион байгуулах 2. Удирдах зөвлөлийг байгуулан, ажиллах журмаа боловсруулан, баталж мөрдөж ажиллах 3. Захирал Удирдах зөвлөлтэй гэрээ байгуулж, ажлын үр дүнг тооцон, урамшуулах, хариуцлага тооцох зэрэг арга хэмжээг авч ажиллах 4. Орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулах, өмч хөрөнгийг шинэчлэх, ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх талаар санал санаачлагатай ажиллах
2	Орлогоо нэмэгдүүлэх талаар санал санаачлагатай ажилладаггүй.	1. Орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг авахгүйгээр орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэхэд анхаарч, эдийн засгийн тооцоо судалгааг хийн, өөрийн орлогын эх үүсвэрийг 100 хувь бүрдүүлэхээр нөөц боломжуудыг дайчлан ажиллах

		2. Байгууллагын үйл ажиллагааг тогтмол явуулах, жилийн эцэст алдагдалтай ажиллахгүй байхаар захирал ажлаа төлөвлөн хэрэгжүүлэх
3	Захирал ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргалгүйгээр ажилд томилж, хамтран ажилласан иргэнтэй гэрээ байгуулдаг.	1. Захирал шинээр ажилтан томилох, гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг заавал гарган, удирдах дээд албан тушаалтнаар баталгаажуулж хэвших 2. Дээрх гаргасан мэдэгдлийг тухай бүрд нь хуулинд заасны дагуу шилэн дансны мэдээлэлд тогтмол байршуулан ажиллах 3. Хамтран ажиллах иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд удирдах дээд байгууллагаас хяналтыг тогтмол тавьж ажиллах
4	Цалин илүү, дутуу олгосон, ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг буруу бичдэг, цалин ээлжийн амралтын цалин давхардуулсан, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчтай эцсийн тооцоо хийдэггүй.	1. Ээлжийн амралтын мэдэгдлийг хэдий хугацаанд ногдох амралтаа эдлэж байгааг албан хаагч бүрээр үнэн зөв бичиж хэвших 2. Ээлжийн амралтын хугацааг албан хаагч бүрээр дахин дахин сайтар нягтлан шалгадаг байх, ээлжийн амралтын цалинг илүү, дутуу олгохгүй байх 3. Ээлжийн амралт эдэлж байх хугацаандаа ажилласан албан хаагчийн ээлжийн амралтыг ажлын ачааллаас хамааруулан хэсэгчлэн биеэр эдлүүлэхээр зохицуулалтыг хийж хэрэгжүүлэх 4. Сарын дундуур шинээр томилогдон ажилд орсон албан хаагчдад тухайн сарын ажилласан хоногт нь ногдох цалинг бодож олгож хэвших 5. Албан тушаал ахиж байгаа ажилтны цалинг үнэн зөв бодож олгох 6. Дотоод хяналтын баг болон захирал цагийн баланс гаргалт, цалин бодолтод хяналтыг хэрэгжүүлж ажиллах 7. Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчидтай эцсийн тооцоог заавал хийж хэвших
5	Тэтгэмж олгосон зарцуулалтын баримт байхгүй, төлбөрийн и-баримт дутуу байхад ажил гүйлгээг хийж, хяналтыг бүрэн гүйцэд тавиагүй.	1. Захирлын тушаалаар тэтгэмж болон хөрөнгийн зардал гаргахдаа мөнгө хүсэх өргөдөл болон зарлагын баримт, нэхэмжлэх зэрэг холбогдох баримтуудыг бүрэн хавсаргаж байх 2. Харилцагч иргэн, ААНэгжээс төлбөрийн и-баримтыг бүрэн гүйцэд авч хэвших 3. Төлбөрийн и-баримт дутуу ажил гүйлгээг хийхгүй байх, үүнд захирал хяналтыг тогтмол тавьж ажиллах
6	Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэггүй.	1. Эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай болох 2. Байгууллагын ажилтан, албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгөх 3. Жил бүр байгууллагын үйл ажиллагаа, дотоод гадаад хүчин зүйлс болон санхүүгийн зорилтуудад учрах эрсдэлийг шинэчлэн тодорхойлж, тохиолдох магадлал учруулах үр дагавраар нь үнэлэх, албажуулах 4. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг үнэлэх, тухайн эрсдэлийг бууруулах, хүлээн зөвшөөрсөн түвшинд

		<p>хүртэл удирдах байдлаар төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах</p> <p>5. Эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагааны төлөвлөгөөний нэгэн хэсэг болгон тайлагнах</p> <p>6. Нэгээс доошгүй албан тушаалтныг эрсдэлийн удирдлагаар сургаж мэргэшүүлэх, чадавхжуулах</p> <p>7. Байгууллагын эрсдлийн түвшинг үнэлэн шатлал ахиулах арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэх</p>
7	<p>Дотоод хяналтын нэгж эрсдэлд чиглэсэн хяналтыг хийдэггүй, дотоод хяналтыг ор нэр төдий хийдэг.</p>	<p>1. Дотоод хяналтын журмандаа дотоод хяналтын нэгжийн ажлыг үнэлэн, биелэлтийг тооцон ажиллах, тухайн ажлыг сайжруулж, үр дүн гарсан тохиолдолд хууль тогтоомжид нийцсэн урамшууллын хөшүүргийг тусгаж өгөх</p> <p>2. Дотоод хяналтын нэгжийн албан хаагчийг холбогдох мэргэшүүлэх байгууллагын сургалтад хамруулж мэргэшүүлэх</p> <p>3. Дотоод хяналтын нэгжийн жилийн төлөвлөгөөг эрсдэлд суурилан төлөвлөх</p> <p>4. Дотоод хяналтын зураглалтай болох, түүнийг хамт олноороо мөрддөг байх</p>
	Нийт өгсөн зөвлөмж	30